

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд 12 арга хэмжээ тусган хэрэгжүүлж байна.

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГ

Нийслэлийн 9-н дүүргийн Засаг дарга нарын дэргэд өсвөрийн шигшээ багийг давхардсан тоогоор спортын 109 төрлөөр байгуулж, 109 дасгалжуулагч, 3150 тамирчинтай үйл ажиллагаагаа явуулж байгаагаас олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээнд 302 удаа оролцож нийт 1311 медаль хүртсэн.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕБС-ИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ” САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/323 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, ОХУ-ын Школьная баскетбольная лига “КЭС-БАСКЕТ” Төрийн бус байгууллага хамтран 2024 оны 12 дугаар сарын 01-нээс 2025 оны 03 дугаар сарын 18-ны хооронд 3 насны ангиллаар, 4 үе шаттай зохион байгуулж 192 сургуулийн охид, хөвгүүдийн 8208 багийн 90550 сурагчид оролцсон.

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээний ахлах насны охид, хөвгүүдийн багуудаас түрүүлсэн 1, 1 баг ОХУ-ын Москва хотноо 2025 оны 09 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд болох “КЭС-БАСКЕТ” олон улсын Супер цомын тэмцээнд оролцох эрхийг олгосон.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН “УЛААНБААТАР ЛИГ” ВОЛЕЙБОЛЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” волейболын тэмцээнийг 2024 оны 12 дугаар сарын 01-нээс 2025 оны 04 дүгээр сарын 23-ний хооронд 2 насны ангиллаар, 3 үе шаттай зохион байгуулж 9 дүүргийн ерөнхий боловсролын 141 сургуулийн охид, хөвгүүдийн 540 багийн 67120 мянга сурагч оролцсон бол нийслэлийн шигшээ тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд нийслэлийн шатанд дунд, ахлах насны шилдэг нийт 42 сургуулийн 64 багийн 832 тамирчид өрсөлдсөн.

Агуу эх орны дайны ялалтын 80 жилийн ойд зориулсан “Агуу ялалт-Агуу нөхөрлөл” уриатай “Ялалтын цом” волейболын нөхөрсөг тэмцээнийг 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж нийт 4 багийн 48 сурагч өрсөлдсөн.



ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ “ХАНГАРДИ” НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/489 дүгээр захирамжаар Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын ширээний теннисний холбоотой хамтран Олон улсын ширээний теннисний өдөрт зориулсан “Хангарди” ширээний теннисний тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд төв асарт зохион байгуулсан.

Арга хэмжээнд нийт 30 байгууллагын 1500 иргэд, тамирчид оролцсон байна.



”УЛААНБААТАР МАРАФОН-2025” ОЛОН УЛСЫН ГҮЙЛТ

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Монгол улсад гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр, залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээж, зорилгодоо хүрэх тэсвэр хатуужил, бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэдийг өдөр тутмын биеийн тамираар хичээллэх идэвх санаачилгыг дэмжих зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/402, А/565, А/649 дүгээр захирамжийн дагуу “Улаанбаатар марафон” 10 дахь удаагийн олон улсын гүйлтийг 05 дугаар сарын 24-ний өдөр амжилттай зохион байгуулсан.

“Улаанбаатар марафон 2025” олон улсын гүйлтийг 42 км 18-аас дээш нас, ХБИ, гар дугуйн уралдаан, 21 км-ийн зайг 18-34, 35-54, 55-аас дээш нас, ХБИ, 5 км-ийн зайг 12-17 нас, 18-аас дээш насны эрүүл мэндийн гүйлт, 1,5 км (хараагүйны бэрхшээлтэй, тэргэнцэртэй гэр бүл) 400м, 800м-ийн зайг тусгай олимпын тамирчид гэсэн ангиллаар тус тус зохион байгуулж нийт 27789 иргэд цахимаар, 2211 иргэн ивээн тэтгэгч байгууллагын төлөөлөл бүртгүүлэн нийт 40 орны 30000 иргэн (үүнээс 4 улсын 6-н шилдэг гүйгч урилгаар) оролцсон.



БНСУ-ЫН ГУАНЖУ ХОТЫН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ЖИОН ГАПСУ ТЭРГҮҮТЭЙ 7 ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АЖЛЫН АЙЛЧЛАЛ

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Биеийн тамир, спортын газар болон БНСУ-ын Гуанжү хотын Биеийн тамир, спортын холбооны хооронд биеийн тамир, спортын харилцан хамтын ажиллагааг эрчимжүүлэх, харилцан зөвшилцлөөр дамжуулан эгч дүүгийн харилцаа холбоо тогтоох чиглэлээр санамж бичиг байгуулах зорилгоор Улаанбаатар хотноо ажлын айлчлал хийсэн БНСУ-ын Гуанжү хотын Биеийн тамир, спортын холбооны ерөнхийлөгч Жион Гапсу тэргүүтэй 7 төлөөлөгчийг 2025 оны 06 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд хүлээн авах бэлтгэл ажлыг ханган, “Санамж бичиг” зурах ажиллагааг зохион байгуулсан.

“ДАНШИГ НААДАМ – ХҮРЭЭ ЦАМ” НААДАМ

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/166 дугаар захирамжаар Монголын өв соёлын “Даншиг наадам – Хүрээ цам” наадмын Буриад бөх, Өвөр Монгол бөхийн барилдааныг 06 дугаар сарын 21, 22-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.

**“АЗИЙН ӨСВӨРИЙН ЗАЛУУЧУУДЫН
СПОРТ СОЛИЛЦООНЫ НААДАМ-2025” АРГА ХЭМЖЭЭ**

Улаанбаатар, Токио хотуудын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 08 дугаар сард Япон улсын Токио хотноо “Азийн өсвөрийн залуучуудын спорт солилцооны наадам-2025” арга хэмжээнд бадминтон, парабадминтон, ширээний теннис, пара ширээний теннисний нийт 23 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчдыг оролцуулахаар төлөвлөж байсан боловч Дэлхийн хөнгөн атлетикийн 2025 оны аварга шалгаруулах тэмцээн болон "Токио-2025" дифлимп-эд бэлтгэх цаг хугацаатай учир "Олон улсын залуучуудын спорт солилцооны наадам-2025" зохион байгуулах боломжгүй болсон.

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС